БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2020/156/СТА-ТШЗ


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цээням
Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn
Аудитор: П.Амаржаргал
Утас: 88106992 Цахим хаяг: amar_802002@yahoo.com



Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор
2020 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ....3
2 Аудитын тайлан....5
2.1. Оршил .... 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .... 5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .... 6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .... 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.... 7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.... 8
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .... 8
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .... 8
2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ....8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .... 9
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .... 9
2.11. Шилэн дансны мэдээлэл .... 9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .... 10
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.... 10
3 Аудит хийсэн санхүүгийн тайлан .... 11
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .... 11
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.... 12
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .... 13
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .... 15
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .... 16

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.01.30 № 1/25

танай ______________-ны №______________-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Н.БЯМБАДОРЖ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

2519392

2

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Мэргэжлийн хяналтын газрын дарга Бямбадорж-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.10-наас 2020.01.13–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.01.27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-ын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.08-ны өдрийн 01/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь "Үндсэн хуулиар тогтоогдсон хүний эрхийн хэм хэмжээ, түүнд нийцүүлэн гаргасан салбарын хууль тогтоомж, стандартуудыг орон нутагт хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж үнэлгээ дүгнэлт өгч, оршиж буй дутагдлыг арилгуулах хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж ажиллах" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Мэргэжлийн хяналтын газар нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Эрүүл ахуй халдвар хамгааллын чиглэл
2. Хүнсний чанар стандартын хяналтын чиглэл
3. Эмчилгээний чанарын хяналтын чиглэл
4. Боловсрол соёлын хяналтын чиглэл
5. Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын чиглэл
6. Мал эмнэлгийн хяналтын чиглэл
7. Эм био бэлдмэлийн хяналтын чиглэл
8. Тээвэр /Авто зам машин механизм/-ын хяналтын чиглэл
9. Барилга техникийн хяналтын чиглэл
10. Эрчим хүч / Харилцаа холбоо/ -ний хяналтын чиглэл
11. Хэмжилзүй /Цацраг/-н хяналтын чиглэл
12. Байгаль орчны хяналтын чиглэл

13. Геологи уул уурхайн хяналтын чиглэл
14. Газрын харилцаа, геодиз зураг зүйн хяналтын чиглэл
15. Нийгмийн хамгааллын хяналтын чиглэл
16. Хөдөлмөрийн хяналтын зэрэг тус бүрийн хяналтын чиглэлүүдээр төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулж байна.

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мэргэжлийн хяналтын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн хяналт, шалгалтын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байгууллагын үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчинд шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Интерактив Би Ай ХХК-ний "EMERALD" санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Мэргэжлийн хяналтын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 33 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 17 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн *нийт зардл*ын *2* хувиар сонгов.

Үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын суурийг энэ үзүүлэлтээр сонгосонтой холбоотой юм.

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн *нийт зардал* 661.4 сая төгрөг бөгөөд түүний *2* хувь болох *13,2* сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 26 горим сорил гүйцэтгэж, 26 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Мэргэжлийн хяналтын газар нь чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 577,9 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 577.3 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь нийт зарцуулаагүй үлдэгдэл 0,8 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна. Мөн 2019 онд хүүхдээ асрах чөлөөтэй эхийн орон тоо сул байснаас шалтгаалж цалингийн зардлын хэмнэгдсэн 7.9 сая төгрөгийг Ахмадын тухай хуулийн 14.7-т заасны дагуу ахмадын сан байгуулж дансанд төвлөрүүлэн, байгууллагын санхүүгийн тайланд нэгтгэн тайлагнаж оны эцэст харилцах дансанд үлдэгдэлтэй байна.

Аж ахуй нэгж болон ард иргэдийн хүсэлтээр хийгдэх шинжилгээний тоо жил ирэх тусам өсч байгаатай холбоотойгоор 2019 оны өөрийн орлогоор 7.0 сая төгрөг оруулахаар төлөвлөн 14.4 сая төгрөг оруулж орлогыг Сангийн яамны орлогын дансанд бүрэн төвлөрүүлсэн байна.

### 2.11. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

2019 оны мэдээлэл оруулсан байдал дараах байдалтай байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 3 | 1 | |
| 3 | Улирал бүр | 4 | 16 | 16 | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 36 | | |
| | Тухай бүр | 8 | 96 | 92 | 4 | |
| | Нийт | 30 | 163 | 156 | 5 | 2 |

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

## 2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **41146978.80** | **52223604.45** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 7975726.00 |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 0.00 | 7975726.00 |
| 3121 | **Төгрөг** | 0.00 | 7975726.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 7975726.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 41146978.80 | 44247878.45 |
| 351 | **Түүхий эд материал** | 17080681.30 | 17550824.63 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6489109.65 | 9228765.85 |
| 35130 | Эм боох материал | 10591571.65 | 8322058.78 |
| 354 | **Хангамжийн материал** | 24066297.50 | 26697053.82 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3043239.06 | 3992932.06 |
| 35420 | Аж ахуйн материал | 15719493.00 | 16766443.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 140200.00 | 112200.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 4825495.44 | 5496553.20 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 337870.00 | 328925.56 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1503287526.90** | **1453567321.59** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1503287526.90 | 1453567321.59 |
| 392 | **Биет хөрөнгө** | 1421665688.70 | 1373799117.04 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1296852003.00 | 1296852003.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | -31152406.90 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 79338000.00 | 80338000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -74849964.08 | -79338000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 262981809.00 | 270036569.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -156317450.92 | -175707784.96 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 37468907.00 | 39887907.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -25084915.30 | -28194632.60 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 2000000.00 | 2000000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -722700.00 | -922537.50 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 81621838.20 | 79768204.55 |
| 39301 | Програм хангамж | 1162200.00 | 1262200.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1162200.00 | -1162200.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 82805000.00 | 82845000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -1183161.80 | -3176795.45 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1544434505.70** | **1505790926.04** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1544434505.70** | **1505790926.04** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1544434505.70 | 1505790926.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1087914987.82 | 1087914987.82 |
| 51101 | Өмч: - төрийн | 1087914987.82 | 1087914987.82 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | -26543154.53 | -64674652.19 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -135832614.02 | -26031072.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 109289459.49 | -38643579.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 483062672.41 | 482550590.41 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1544434505.70** | **1505790926.04** |

### 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **699060145.77** | **622790508.44** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **144362588.77** | **39019208.44** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 144362588.77 | 39019208.44 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 144362588.77 | 39019208.44 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12062700.00 | 14657160.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 134981.77 | 8110088.44 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 132164907.00 | 16251960.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **554697557.00** | **583771300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 545906400.00 | 577911300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 545906400.00 | 577911300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1130360.00 | 5860000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1130360.00 | 5860000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 7660797.00 | 0.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 7660797.00 | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **589770686.28** | **661434088.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **589770686.28** | **661434088.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 561265565.83 | 644362411.54 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 343910053.00 | 398495083.00 |
| 210101 | Үндсэн цалин | 279040504.00 | 380489354.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13804600.00 | 13827800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 51064949.00 | 4177929.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 42098673.32 | 49987166.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28242421.64 | 34336543.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3530300.38 | 4039595.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2762801.00 | 3139511.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 687560.00 | 770139.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6875590.30 | 7701377.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57715340.00 | 59139711.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1921341.00 | 2896870.00 |
| 210302 | Түлш, халаалт | 47297079.00 | 47297081.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8496920.00 | 8945760.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24868230.32 | 29034828.68 |
| 210401 | Бичиг хэрэг | 4200970.48 | 6112397.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11820145.84 | 14957442.24 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5820732.00 | 5895395.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 40000.00 | 30000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140000.00 | 200000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2846382.00 | 1839594.44 |
| **2105** | **Нормативт зардал** | 6007218.40 | 8606256.67 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3760598.40 | 6356256.67 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 2246620.00 | 2250000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9948300.00 | 4379100.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 350000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 9598300.00 | 4379100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 12487500.00 | 19191800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12487500.00 | 19191800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5488260.00 | 6177800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1316560.00 | 3020000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 250000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2074500.00 | 2074500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 232300.00 | 280400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88000.00 | 88000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1753000.00 | 441000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 23900.00 | 23900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 58741990.79 | 69350665.31 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2857500.00 | 357000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 55884490.79 | 68993665.31 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 28505120.45 | 17071676.56 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10085797.00 | 1900000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 7660797.00 | 0.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2425000.00 | 1900000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 12018400.00 | 14389860.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12018400.00 | 14389860.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6400923.45 | 781816.56 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6400923.45 | 781816.56 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **109289459.49** | **-38643579.66** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **109289459.49** | **-38643579.66** |

## 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **566760257.00** | **606404186.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12062700.00** | **22632886.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12062700.00 | 22632886.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 12062700.00 | 22632886.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 12062700.00 | 14657160.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 7975726.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **554697557.00** | **583771300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 545906400.00 | 577911300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 545906400.00 | 577911300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1130360.00 | 5860000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1130360.00 | 5860000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 7660797.00 | 0.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 7660797.00 | 0.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **543533958.00** | **595129460.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **543533958.00** | **595129460.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **515028837.55** | **578057783.44** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 343910053.00 | 398495083.00 |
| 210101 | Үндсэн цалин | 216036904.00 | 304562083.00 |
| 210102 | Нэмэгдэл | 63003600.00 | 80105200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13804600.00 | 13827800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 51064949.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41963691.55 | 49852804.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28242421.64 | 34336543.33 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3530300.38 | 4039595.65 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2627819.23 | 3005149.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 687560.00 | 770139.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6875590.30 | 7701377.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 57715340.00 | 59139711.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1921341.00 | 2896870.00 |
| 210302 | Түлш, халаалт | 47297079.00 | 47297081.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8496920.00 | 8945760.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 27924282.00 | 28590295.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4101100.00 | 5228400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15256500.00 | 15628500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5820732.00 | 5895395.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 40000.00 | 30000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 140000.00 | 200000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2565950.00 | 1608000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 8710101.00 | 8936400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6463481.00 | 6686400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2246620.00 | 2250000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12138200.00 | 5350700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4800000.00 | 999600.00 |
| 210604 | Урсгал засвар | 7338200.00 | 4351100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 12487500.00 | 19191800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12487500.00 | 19191800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7322170.00 | 8143990.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1930320.00 | 3160000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | 250000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2074500.00 | 2074500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 232300.00 | 280400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88000.00 | 88000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2232350.00 | 1526950.00 |
| 210807 | Газрын төлбөр | 23900.00 | 23900.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 740800.00 | 740240.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2857500.00 | 357000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2857500.00 | 357000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28505120.45** | **17071676.56** |

| | | | |
|---|---|---|---|
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 10085797.00 | 1900000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 7660797.00 | 0.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2425000.00 | 1900000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 12018400.00 | 14389860.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12018400.00 | 14389860.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 6400923.45 | 781816.56 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6400923.45 | 781816.56 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **23226299.00** | **11274726.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **23226299.00** | **3299000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **23226299.00** | **3299000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 23226299.00 | 3299000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 23226299.00 | 3299000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-23226299.00** | **-3299000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 7975726.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 7975726.00 |

## 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,013,289,987.82 | 1,188,002.26 | -136,218,345.02 | | 878,259,645.06 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,013,289,987.82** | **1,188,002.26** | **-136,218,345.02** | **0.00** | 878,259,645.06 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 74,625,000.00 | 482,260,401.15 | | | 556,885,401.15 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | -385,731.00 | 385,731.00 | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 109,289,459.49 | | 109,289,459.49 |
| C08 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,087,914,987.82** | **483,062,672.41** | **-26,543,154.53** | **0.00** | 1,544,434,505.70 |
| D01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,087,914,987.82** | **483,062,672.41** | **-26,543,154.53** | **0.00** | 1,544,434,505.70 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,087,914,987.82** | **483,062,672.41** | **-26,543,154.53** | **0.00** | 1,544,434,505.70 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | -512,082.00 | 512,082.00 | | 0.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -38,643,579.66 | | -38,643,579.66 |
| D09 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,087,914,987.82** | **482,550,590.41** | **-64,674,652.19** | **0.00** | **1,505,790,926.04** |

## 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 545906100.00 | 539549776.55 | 577911300.00 | 577396783.44 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 545906100.00 | 539549776.55 | 577911300.00 | 577396783.44 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 543479700.00 | 537124776.55 | 576011300.00 | 575496783.44 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 348927000.00 | 344002544.55 | 398786300.00 | 398499487.44 |
| 210101 | Үндсэн цалин | 237145100.00 | 232287044.55 | 304810100.00 | 304566487.44 |
| 210102 | Нэмэгдэл | 63003600.00 | 63003600.00 | 80105200.00 | 80105200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 13871000.00 | 13804600.00 | 13871000.00 | 13827800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 34907300.00 | 34907300.00 | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 41871200.00 | 41871200.00 | 49848400.00 | 49848400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27914200.00 | 28149930.09 | 33896900.00 | 33896900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3489300.00 | 3530300.38 | 3987900.00 | 3987900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2791400.00 | 2627819.23 | 3190300.00 | 3190300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 697800.00 | 687560.00 | 797600.00 | 797600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6978500.00 | 6875590.30 | 7975700.00 | 7975700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 58870800.00 | 57715340.00 | 59320800.00 | 59139711.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3046500.00 | 1921341.00 | 3046500.00 | 2896870.00 |
| 210302 | Түлш, халаалт | 47297100.00 | 47297079.00 | 47297100.00 | 47297081.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 8527200.00 | 8496920.00 | 8977200.00 | 8945760.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28126500.00 | 27924282.00 | 27936400.00 | 27894295.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 4060500.00 | 4101100.00 | 5228400.00 | 5228400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 15256500.00 | 15256500.00 | 14633500.00 | 14633500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6173800.00 | 5820732.00 | 5973800.00 | 5895395.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 60000.00 | 40000.00 | | 30000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 125000.00 | 140000.00 | 250000.00 | 200000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2450700.00 | 2565950.00 | 1850700.00 | 1907000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 8936400.00 | 8936400.00 | 8936400.00 | 8936400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6686400.00 | 6689780.00 | 6686400.00 | 6686400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2250000.00 | 2246620.00 | 2250000.00 | 2250000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 35151100.00 | 35138200.00 | 8351100.00 | 8350700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 23000000.00 | 23000000.00 | 3000000.00 | 3000000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4800000.00 | 4800000.00 | 1000000.00 | 999600.00 |
| 210604 | Урсгал засвар | 7351100.00 | 7338200.00 | 4351100.00 | 4351100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 12490600.00 | 12487500.00 | 14686800.00 | 14686800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12490600.00 | 12487500.00 | 14686800.00 | 14686800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6248600.00 | 6191810.00 | 7787600.00 | 7783990.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 800000.00 | 799960.00 | 2800000.00 | 2800000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | | 250000.00 | 250000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2074500.00 | 2074500.00 | 2074500.00 | 2074500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 283400.00 | 232300.00 | 283400.00 | 280400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88000.00 | 88000.00 | 88000.00 | 88000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2238000.00 | 2232350.00 | 1527000.00 | 1526950.00 |
| 210807 | Газрын төлбөр | 23900.00 | 23900.00 | 23900.00 | 23900.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 740800.00 | 740800.00 | 740800.00 | 740240.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2857500.00 | 2857500.00 | 357500.00 | 357000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2857500.00 | 2857500.00 | 357500.00 | 357000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2426400.00 | 2425000.00 | 1900000.00 | 1900000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2426400.00 | 2425000.00 | 1900000.00 | 1900000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2426400.00 | 2425000.00 | 1900000.00 | 1900000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 545906400.00 | 539549766.55 | 577911300.00 | 577396783.44 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 545906400.00 | 539549766.55 | 577911300.00 | 577396783.44 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 545906400.00 | 539549766.55 | 577911300.00 | 577396783.44 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 38.00 | 38.00 | 38.00 | 36.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 24.00 | 23.00 | 24.00 | 21.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 8.00 | 13.00 | 14.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 6.00 | 6.00 | 0.00 | 0.00 |

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР: П.АМАРЖАРГАЛ

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЭНЯМ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ